

## БНХАУ-ЫН АРДЫН БОЛОВСРОЛЫН СИСТЕМ ШИНЭТГЭЛИЙН ЗАМД

С. БААСАНЖАВ

БНХАУ-ын нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт шинэтгэл явуулж байгаа өнөө үед хүн амын дөрөвний нэг хувь нь бичиг үсэгт тайлагдаагүй, тайлагдсан хүмүүсийн зонхилох хэсэг нь бага сургуулийн боловсролтой байгаа Хятадын ардын боловсролын системд шинэтгэл хийх зүй ёсны шаардлага гарч байна. Хятадын боловсролын системийн шинэтгэл нь юуны түрүүн Хятадын эдийн засгийн шинэтгэлтэй холбогдон гарч ирж, орчин үеийн үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй шууд харьцаж чадахуйц мэдлэг боловсролтой ажиллах хүчинг бэлтгэх явдлыг гол зорилтоо болгон дэвшүүлж, бүх нийтийн боловсролын асуудалд онцгой анхаарал тавьж байна.

1949 онд БНХАУ байгуулагдахад Хятадын хүн амын ерөнхий боловсрол маш доогуур, 80% нь бичиг үсэг үл мэдэгчид байв. БНХАУ байгуулагдсаны дараахь эхний 10 гаруй жилд тус оронд социалист нийгмийн үндэс суурь тавигдаж, бүх нийтээр бичиг үсэгтэй болох хөдөлгөөн өрнөж, ардын боловсролын систем тогтов. Харин дараагийн 20-иод жилд хятадын удирдагчдаас явуулсан улс төрийн балмад явууллага нь боловсролын хөгжилд сөрөг нөлөө үзүүлсэнээр барахгүй «Соёлын хувьсгал»-ын жилүүдэд ардын боловсрол бараг уналтанд оржээ.

1978 онд хуралдсан ХКН-ын Ш бүгд хурал Хятадын ард түмний эрх ашигт харшилж байсан урьд өмнөх балмад явууллагыг хянан үзээд улс орноо зогсонги, хаалттай байдлаас гарган цаашид эрчимтэй хөгжүүлэх «түүхэн шийдвэр» гаргасан юм. 1985 онд «Хятадын боловсролын системийг шинэтгэх тогтоол» гарч Хятадын Гэгээрлийн яамыг Улсын боловсролын хороо болгон өргөтгөж даргаар нь тэр үед БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч байсан Ли Пэнг томилжээ. Хятадын ардын боловсролын сургалт нь сургуулийн өмнөх насны хүмүүжил, ерөнхий боловсролын бэлтгэл, мэргэжлийн сургалт, дээд боловсрол, ажилчин, мэргэжилтнүүдийн мэдлэгийг байнга баяжуулж, мэргэшлийг дээшлүүлэх явдлыг зүй ёсоор багтааж байна. Сургуулийн насны хүүхдүүд бага сургуульд зургаан жил, бүрэн бус дунд сургуульд гурван жил (7—9-р анги), бүрэн дунд сургуульд мөн гурван жил (10—12-р анги) суралцаж байна. Хятадын 830 мянган бага сургуульд 151 сая, 93 мянган дунд сургуульд 49 сая сурагч<sup>1</sup> суралцаж байгаа нь БНХАУ байгуулагдахаас өмнөх үетэй харьцуулбал сургуулийн тоо 21,9 суралцагчид 31,5 дахин өссөн болно.<sup>2</sup>

Хятадын ерөнхий боловсролын дунд сургуульд зохион байгуулалтын олон янзын бүтэцтэй сургалт хүмүүжлийн систем байдаг. Үүний нэг хэлбэр нь «зонхилох сургууль» юм. «Зонхилох сургууль» гэж тэргүүний сурган хүмүүжүүлэгчид, шилдэг сурагчдыг сонгон авч сургалтыг явуулдаг үлгэр жишээ дунд сургуулийг Хятадад ингэж нэрлэдэг болно. Хятадын хамгийн тэргүүний «зонхилох сургууль» болох Бээжингийн 2-р дунд сургуулийн бүрэн бус дунд ангид элсэхэд 100 онооны үнэлгээтэй 2 шалгалт өгч 196 оноо, бүрэн дунд ангид элсэхэд 120 онооны үнэлгээтэй 6

шалгалт өгч 714 оноо авч тэнцдэг.<sup>3</sup> Бусад «зонхилох сургуульд» 10 мянган хүүхдээс 300—400 орчмыг шалгаруулан элсүүлдэг байна. «Зонхилох сургуулийг» ердийн дунд сургуульд үлгэр дууриал болгох журмаар анх санаачилсан бол энэ үлгэр жишээ нь ерөнхий боловсролын дунд сургуулийн сургалтанд тэгш бус байдлыг үүсгэснээс «зонхилох сургууль» төгсөгчдийн олонхи нь дээд сургуульд элсэн суралцаж байхад ердийн дунд сургуулиас элсэгчид багасчээ. Ерөнхий боловсролын дунд сургуульд «зонхилох сургуулиас» гадна гадаад хэлний тусгай дунд сургууль гэж байдаг. Гадаад хэлний тусгай дунд сургуулийн сургалт нь ердийн дунд сургуультай адил боловч англи, япон, орос, герман, франц зэрэг гадаад хэлийг тусгайлан заадгаараа онцлог юм. Мөн оюуны хомсдолтой хүүхдэд зориулсан тусгай дунд сургууль, хэв журам зөрчсөн 13-17 насны хүүхдийг сургуулиас завсардуулахгүйгээр хүмүүжүүлдэг 2 жилийн хөдөлмөр сургалтын дунд сургууль бий.

Хятадын техник мэргэжлийн сургууль, техникум, тусгай мэргэжлийн дунд сургуулийн сургалт нь ерөнхий боловсролын бүрэн бус буюу бүрэн дунд боловсролтой, төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн боловсон хүчинг улс ардын аж ахуйн бүхий л салбарт бэлтгэн гаргадаг. Сүүлийн үед тусгай мэргэжлийн сургуулийг анхааран хөгжүүлснээр ТМС, ХАА-н дунд сургууль, техникумд суралцагчид бүрэн дунд сургуульд суралцагчдын 31,5% болон өсөв, Хятадын ТМС, ХАА-н сургуульд 1 сая 745 мянга, тусгай мэргэжлийн дунд сургуульд 1 сая 322 мянга, техникумд 639 мянган хүн тус тус суралцаж байна.<sup>4</sup> Гэвч одоогоор сургалтын энэ систем үйлдвэрлэлийн хөгжлийг гүйцэж амжихгүй байгаа нь боловсон хүчний мэргэжлийн чадвар доогуур түвшинд буйтай холбоотой юм. Энэ нь технологийн нарийн түвэгтэй ажиллагаа ажилчдын мэргэжлийн түвшингээс их түргэн нэмэгдэж байна гэсэн үг юм.

Хятадын ардын боловсролын сургалтанд зохих ёсоор мэргэжил боловсрол олж чадаагүй хүмүүст ажил хөдөлмөрөө эрхлэхийн зэрэгцээ мэдлэг боловсролоо шатлан дээшлүүлэх боломж олгодог насанд хүрэгчдийн сургалт багтдаг. 1987 оны байдлаар насанд хүрэгчдийн тусгай дунд сургууль 4000 гаруй, тариачдын техникийн дунд сургууль 3500, ажилчин албан хаагчдын тусгай дунд сургууль 30 мянга гаруй болж 1 сая 420 мянган хүн тусгай дунд боловсрол олж, 15 сая хүн шинээр бичиг үсэгтэн болжээ.<sup>5</sup>

Хятадын дунд сургуулиудад ерөнхий эрдмийн хичээлээр хэл бичиг, математик, гадаад хэлийг 1000 орчим цаг, физик, хими, түүх, газар зүйн хичээлийг 300-500 орчим цаг бусад хичээлийг арай цөөн цагаар заадаг программтай. Мөн сурагчид сонирхолынхоо дагуу долоо хоногт 30 орчим цагийн нэмэлт хичээлд сууна. Нэмэлт хичээлд тооцоолон бодох машин, электрон техникийн анхны мэдэгдэхүүн, анагаах ухаан, эртний хятад хэл, уран зохиолын түүх, хоёр дахь гадаад хэлний хичээл орно. Дунд сургуулийн хичээлийн төрөл, сургалтын цаг Хятадын автономит район, муж, том хотуудад харилцан адилгүй байдаг. Хятадын дунд сургуулийн хичээлийн программд сурагчдад «улс төрийн зөв чиглэл олгох явдал сургалтын тэргүүн зэргийн зорилт»<sup>6</sup> хэмээн үзэж улс төрийн хичээлээр гоо зүйн хүмүүжил, улс төр, эдийн засаг, хууль зүйн анхны мэдэгдэхүүнтэй танилцуулж байна. Хөдөлмөрийн хичээл нь сурагчдад политехникийн боловсрол эзэмшүүлэх үндэс суурийг тавьдаг тул хятадын дунд сургуулийн 73,9% нь<sup>7</sup> сургалтыг үйлдвэрлэлтэй хос-

лон явуулдаг. 1982 оноос компьютерийн сургалтыг зарим дунд сургуульд нэвтрүүлж эхлэв.

Хятадын боловсролын системд багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ахуй амьдралыг нь сайжруулах асуудал хурцаар тавигдаж ирэв. Багш бол өөрчлөн байгуулалтын нэн чухал хөдөлгөгч хүч билээ. Гэтэл багшийн хөдөлмөрийг дутуу үнэлж байгаагаас тэдний цалин нь ахуй амьдралаа өөд татахад дорвитой нөлөө үзүүлэхгүй байна. Бага сургуулийн багш сард 40 юаний цалин авдаг нь адил боловсролтой бусад системийн албан хаагчдын дундаж цалингаас бага байгаа юм. 1985 оны байдлаар Хятадын дунд сургуульд 2 сая 651600 багш<sup>8</sup> байгаа боловч жижиг хот суурин, зах хязгаар нутгийн сургуулиудад мэргэжлийн болон дадлага туршлагатай багш нар дутагдсан хэвээр байна. Боловсролын системийн шинэтгэлийн явцад Хятадын Улсын боловсролын хороо багш нарын бүтээлч ажиллагааг идэвхжүүлж, мэдлэг боловсролоо тогтмол дээшлүүлж байх хөшүүрэг болгон багш нарын улс төрийн мэдлэг, сургалтын ажлын бүтээлийг харгалзан мэргэжлийн зэргийг тогтоож цалинг зэргийн дагуу олгох боллоо. 1987 оны 10-р сараас бага, дунд сургуулийн багш нарын цалинг 10% нэмэгдүүлэв.<sup>9</sup>

Аливаа дунд сургуулийн сургалтын зорилго нь сурагчдад ерөнхий эрдмийн суурь мэдлэгийг чанартай олгоход чиглэгддэг. Тэгсний дараа л тэдэнд хувийн болон нийгмийн эрх ашиг, өөрийнхөө авьяас билэг, бэлтгэлийн түвшингээ харгалзан дээд сургууль, тусгай мэргэжлийн сургуульд орох уу эсвэл шууд үйлдвэрлэл дээр мэргэжил эзэмших үү гэдгээ сонгох боломж олгох хэрэгтэй. Гэтэл Хятадын ихэнх дунд сургуульд сурагчдын сурлага хүмүүжилд анхаарал тавихгүй дээд сургуульд элсэгчдийн тооны хойноос хөөцөлдөх явдал газар авсан байна. Ийм сургуулиас дээд сургуульд элсэгчид оюутан болсон хойноо сурлагаар хоцорч эхэлдэг. Хятадын Улсын боловсролын хорооны дарга Ли Пэн хэлэхдээ: «Дунд сургуулийн ажлын шалгуур нь дээд сургуульд элсэгчдийг бэлдсэн хувиар бус харин сургууль төгсөгчид нь бүх талын өв тэгш хүмүүжлийг олж чадсан эсэх, социализмын бүтээн байгуулалтын шаардлагыг биелүүлж чадах эсэхээр хэмжигдэнэ»<sup>10</sup> гэжээ. 1986-1987 оны хичээлийн жилээс дунд сургууль төгсөгчдөөс сурлага хүмүүжлээр тэргүүний гоц авьяастай сурагчдыг сургуулийн тодорхойлолтыг үндэслэн дээд сургуульд шалгалтгүйгээр элсүүлэв. Дунд сургууль төгсөгч нь дээд сургуульд элсэх уралдаант шалгалтанд сонгосон мэргэжлийнхээ дагуу шалгагдахаас гадна зохион бичлэг бичдэг. Зохион бичлэг нь хятад хэл, дүрс үсгээ төгс эзэмшсэн хүн ямар ч ажлыг гүйцэтгэж чадна хэмээн үздэг эрт үеэс уламжлагдаж ирсэн шалгалт юм. Шалгалтанд тэнцэгчдийн оноог улсын хэмжээгээр дүгнэж, авсан онооных нь дагуу Бээжингийн Их сургууль, Шанхайн Их сургууль, Хятадын Ардын их сургууль гэх мэтээр бусад сургуулиудад хуваарилдаг ажээ.

ХКН-ын ТХ-ноос ардын боловсролын өнөөгийн төвшин Хятад улсын хөгжлийн шаардлагаас хоцорч байгааг харгалзан үзэж «Боловсролын системийг шинэтгэх» тухай гаргасан 1985 оны тогтоолд ерөнхий боловсролын сургуулийн сургалтын суурь мэдлэг, тусгай мэргэжлийн дунд сургуулийн техникийн боловсролыг суралцагчдад гүн гүнзгий эзэмшүүлж, багш нарыг дахин шалгаруултанд оруулж, тэднийг өөр системд авч ажиллуулахыг хориглон, мэдлэг чадвартайг нь зоригтой дэвшүүлэхээр заасан юм. Мөн боловсролын байгууллагын эрх үүргийг нэмэгдүүлэн бүхий л ажлыг дан ганц дээрээс өгсөн шийдвэрийн

дагуу зохицуулж байсныг болиулжээ. Үүний үр дүнд сургуулийн захиргаа нь боловсон хүчин санхүүгийн асуудлыг бие даан шийдвэрлэх эрхтэй болов. Боловсролын системийг шинэтгэх тогтоолд насанд хүрэгчдийн сургалтанд улам олон хүнийг хамруулах, хувь хүмүүст сургууль эрхлэн байгуулахыг зөвшөөрөх тухай тусгай заалтууд оржээ.

1986 онд бүх нийтийг 9 жилийн боловсрол эзэмшүүлэхээр заасан Хятадын боловсролын хууль батлагджээ. Энэ хуулинд өсвөр насны бүх хүүхдийг бага сургуулийн боловсролтой болгож 1990 оны үед гадаад ертөнцтэй өргөн харьцаатай эдийн засгийн хөгжил бүхий далайн эрэг орчмын муж, том хотуудад 9 жилийн сургалтыг хэрэгжүүлж, улмаар 1995 онд хүн амын тэн хагас суудаг төвлөрсөн суурин газар, 2000 оны эхэнд Хятадын хүн амын 80 % амьдарч буй бусад нутагт шат дараалан төлөвлөгөөтэй хэрэгжүүлэхээр заасан юм. Эдгээр хууль тогтоол нь Хятадын боловсролын системийг улам боловсронгуй болгож, боловсролын салбарт улсаас үзүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, сургуулийн аж ахуйг тооцоотой удирдах боломжийг бий болгон, хувийн сургуулиудад улсын сургуулийн байрыг хичээлийн бус цагаар авах, тэтгэвэрт гарсан ахмад багш нараар хичээл заалгахыг зөвшөөрчээ. Гэхдээ боловсролын системийг шинэчлэх бүх тодорхой замыг эдгээр хууль тогтоолууд тодорхойлсон гэж үзвэл буруу болох билээ. Энэ бол амаргүй хэрэг юм. Хятадын боловсролын хуулинд хятад биш үндэстэн амьдарч буй нутагт 9 жилийн боловсролыг хэрэгжүүлэх хугацааг тодорхой товлон заалгүй өнгөрчээ. Мөн 80-аад оноос хэрэгжүүлж эхэлсэн төлөвлөгөөт төрөлтийн бодлогыг боловсролын системийг хөгжүүлэхэд харгалзах хэрэгтэй гэж Хятадын хэвлэлд бичиж байна.

Хятадын боловсролын системд хийх шинэтгэл нь хүн амын 80 % амьдардаг хөдөө тосгодод боловсролын асуудлыг хэрхэн хэрэгжүүлэхээс ихээхэн шалтгаална. Тариачдын хувиа аргацаасан аж ахуй, тэднээс боловсролд хандах хандлаганд нөлөөлж зарим тариачид хүүхдээ сургуульд суулгалгүйгээр хувийн аж ахуй дээрээ үе улираан үлдээх зорилгоор тэдэнд мэдлэг боловсрол олгох явдлыг огт хэрэгсэхгүй байна. Сургалтын хөлс сайн дурын үндсэн дээр байх ёстой гэсэн заалт мөрдөгдөхгүй нэг хүүхдийг сургахад бага сургуульд 42 юань, дунд сургуульд 50 юань төлдөг нь хүүхдийг сургуульд суулгахад хүндрэл учруулж байна гэсэн захидал хятадын олон мужийн тариачдаас иржээ.<sup>11</sup> Гэрээт хариуцлагын систем хөдөө тосгодод хэрэгжиж, тариачдын аж амьдрал дээшилж байгаа боловч сургуульд хүүхдүүд бүрэн хамрагдахгүй байдал одоо ч оршсоор байна. 1985 онд хятадын бага сургууль төгсөгчдийн 31,6% нь бага сургуулиас цааш дэвшин суралцсангүй<sup>12</sup>. Дунд сургуулийн байдал энэ талаар ямар байгааг хятадын нэг тосгоны сургууль дээр авч үзэхэд бүрэн бус дунд сургуульд дэвшин суралцсан сурагчдын 76% нь 1-р ангиас, 52,6% нь 2-р ангиас, 15% нь 3-р ангиас гарчээ.<sup>13</sup> Хүүхдүүд сургуулиас завсардах явдалд шалгалтанд тэнцэхгүй хасагдахаас гадна гэр орны ахуй байдал нөлөөлж байна. Эцэг, эхчүүд тусгай мэргэжил, дээд боловсрол эзэмших найдвар багатай хүүхдэд дэмий хоосон зардал гаргах, эсвэл хүүхэд нь сурлагандаа сайн бол ямар нэгэн мэргэжил эзэмшээд хот суурин бараадвал хувийн аж ахуй нь өвлөх эзэнгүй хоцрохоос болгоомжлон хүүхдээ сургуулиас гаргаж байна. Энэ байдлыг зогсоохын үүднээс Хятадын боловсролын байгууллагууд янз бүрийн арга хэмжээ авч эхлэв. Тухайлбал Фузянь, Цзянсу мужид 12—16 насны сургуулиас завсардсан хүүхдийг албан журмаар

бичиг үсгийн дугуйланд суулгаж, бага сургуулийн боловсролгүй залуу хүнийг ажилд авахгүй байх шийдвэр гаргасан бол Шаньси мужид 7 нас хүрсэн хүүхдээ бага сургуульд суулгаагүй эцэг эхээс хүүхдийг нь 16 нас хүртэл 50 юаний татвар авч байна.<sup>14</sup> Мэдлэг боловсрол ямар хэрэгтэйг Хятадын тариачид улам бүр ухамсарлах болов. Боловсролын системийн шинэтгэл нь хот тосгоны ялгааг багасгах нийгмийн хөгжлийн явцад үйлчилж байна. Сүүлийн жилүүдэд Хятадын хөдөө тосгоноос 100 сая тариачин явсан бол 2000 он гэхэд 300 сая тариачин суурин газар шилжин суух ажээ.<sup>15</sup>

Хятад улс бүх нийтийн боловсролын түвшингээр өнөөдөр дэлхийн олон орноос доогуур, тухайлбал хөдөөд сургуулийн насны хүүхдийн 40% нь, хотод 6% нь сургуульд сурдаггүй,<sup>16</sup> Хятад улс нэг сурагчийн сургалтанд жилд гуравхан юань зарцуулж байгаа нь НҮБ-ийн гишүүн орнуудын дотор 130-р байранд<sup>17</sup> орж байгаагаас харагдаж байна. Боловсролын талаар Хятадын удирдлагаас сүүлийн үед авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд нь энэхүү хоцрогдлыг ойрын хугацаанд арилгахад чиглэгдэж ирэв.

Хятад орны ирээдүй, ерөөс социализмын хувь заяа өнөө болон хойч үеийнхний боловсрол, мэргэжлийн бэлтгэл ямар байхаас шийдвэрлэх хэмжээгээр шалтгаална. 1987 оны 10-р сард хуралдсан ХКН-ын XIII их хурал Хятадын эдийн засаг, шинжлэх ухаан, соёл боловсролыг цэцэглүүлэн хөгжүүлэх зорилт дэвшүүлсэн билээ. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд зөвхөн эхлэлийн шатандаа явж байгаа Хятадын боловсролын системийн шинэтгэл онцгой үүрэг гүйцэтгэх болно.

<sup>1</sup> «Жэньминь жибао» 1985.3.10

<sup>2</sup> «Хятадын ерөнхий боловсролын дунд сургуулийн сургалт» «ХЕБДСС» Бээжин 1986, 3-р тал

<sup>3</sup> «Проблемы дальнего востока» 1987. No 379-р тал

<sup>4</sup> «Жэньминь жибао» 1985.3.10

<sup>5</sup> «Жэньминь жибао» 1987.1.9

<sup>6</sup> «Гуанмин жибао» 1987.4.3

<sup>7</sup> «ХЕБДСС» Бээжин, 1986. 41-р тал

<sup>8</sup> «ХЕБДСС» Бээжин, 1986, 41-р тал

<sup>9</sup> «Жэньминь жибао» 1987.12.1

<sup>10</sup> «Жэньминь жибао» 1987.5.3.

<sup>11</sup> «Цзяоюй яньцзю» 1985, No 8, 28-р тал

<sup>12</sup> «ХЕБДСС» Бээжин, 1986. 3-р тал

<sup>13</sup> «Проблемы Дальнего Востока» 1987. No 2. 123-р тал

<sup>14</sup> «Гуанмин жибао» 1984.2.25 .

<sup>15</sup> «Экономика» сэтгүүл 1988 он No 1 19-р тал

<sup>16</sup> «Правда» 1986.8.19

<sup>17</sup> «10 жилийн дараахь Хятад орон» Токио 1986. 60-р тал